

**“Хариуцлагын карт”-аар хүүхэд нэг бүрийг
үүрэг хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэн
хөгжүүлэх нь**

ИЛТГЭГЧ: О.БУЯНХИШИГ

Агуулга

Оршил:

Нэгдүгээр бүлэг: Үүрэг, хариуцлагын талаарх онол практикийн зарим асуудал

1.1 Үүрэг гэж юу болох, түүний ангилал

1.2 Хариуцлага гэж юу вэ?

1.3 Үүрэг хариуцлагын нэгдэл

Хоёрдугаар бүлэг: “Хариуцлагын карт”-ыг туршин хэрэгжүүлсэн байдал

2.1 “Хариуцлагын карт” хэрэглэх болсон шалтгаан

2.2 “Хариуцлагын карт”-ын талаар боловсруулсан журам

2.3 “Хариуцлагын карт”-ыг хөтөлж ирсэн туршлага, үр дүн

2.4 Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулах талаар хийж буй ажлууд

Дүгнэлт

Ном зүй

Оршил

Орчин үед хүүхдийн хүмүүжил, төлөвшил, ёс суртахуун доройтож, бусдын эрхийг хөндөх, ахмад үеэ үл хүндэтгэх, үүргээ ухамсарлахгүй байх зэрэг сөрөг үзэгдэл ихэссээр байна.

Мөн Хүүхдийн эрхийг хамгаалах хууль, Суралцагчдын дүрэм, тэдний дэг журмыг хангах цөөн баримт бичгээс өөр хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх, үүргийг нь ухамсарлуулах бодит ажил цөөн байгаа нь зөрчил, дутагдал ихэсэхэд нөлөөлж байна гэж үзэж байна.

Тэгвэл ямар ажил зохион байгуулбал үр дүнтэй талаар сурагчдаас авсан санал асуулгаар, сурагчид үүргээ бүрэн биелүүлдэггүй, тэдний эрх хэн нэгний үйлдлээр зөрчигддөг, эрхийн зөрчлийг багасгах арга замууд шаардлагатай, сурагчдыг үүргээ биелүүлдэг, хариуцлагатай болгоход нөлөөлөх ажлуудын талаар тодорхой саналуудыг авч, үйл ажиллагаандаа тусгасан юм.

Ингэснээр ангийнхаа сурагчдын дунд “Хариуцлагын карт”-ыг санаачлан гаргаж, хориглосон үйлдлийг санаатай болон санамсаргүй хийсэн тохиолдолд уг картанд тэмдэглэл /тусгай цоологчоор/ хийхээр журам гарган мөрдөж ажиллалаа.

Мөн “Сурагчийн үнэлгээ”-ний дэвтэр боловсруулан мөрдөж, төлөвшил, хүмүүжлийн талаар сурагч, багш, эцэг эхийн зүгээс тус бүртээ тэмдэглэл хөтлөн ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн.

Дээрх ажлуудын үр дүнд сурагчид “Үүрэг”, “Хариуцлага” гэдгийг гүнээ ухамсарлаж, журамд заасан зөрчлийг гаргахгүй байхад ихэд анхаарч, хичээл сургалтын явцад болон бусад үеэр сурагчийн үүргээ чанд биелүүлдэг болж байна.

Уг судалгааны ажлаараа Здах жилдээ хэрэгжүүлсэн “Хариуцлагын карт”-ын журам, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар дурдах болно.

Журмыг боловсруулахдаа Сургуулийн үлгэрчилсэн дүрэм, Суралцагчдын дүрэм болон “Сургуулийн сурагчдын дагаж мөрдөх журам”, сурагчдаас авсан судалгааг үндэс болгосон.

Мөн энэ талаарх хууль эрх зүйн болон сурган хүмүүжүүлэх зүйн үндсэн баримт бичгүүдэд тулгуурласан. Тухайлбал:

1. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
2. ЕБС-ийн суралцагчдын дүрэм
3. МУ-ын Боловсролын тухай хууль,
4. Бага дунд боловсролын тухай хууль,
5. Үүрэг, хариуцлагын талаарх судлаачдын үзэл баримтлал г м

Судалгааны зорилго нь Сурагчдын үүрэг хариуцлагыг сайжруулах, тэднийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, хүүхдийн эрхийн зөрчил, үе тэнгийнхний дарамт, үл ойлголцол зэргээс сэргийлэх, явдал юм.

Судалгааны зорилт:

1. Сурагчдын үүрэг, хариуцлагыг сайжруулах аргачлал боловсруулах,
2. “Хариуцлагын карт”-ыг хэрэгжүүлж буй байдлыг судлах, дүн шинжилгээ хийх,

Судалгааны таамаглал:

“Хариуцлагын карт”-ыг мөрдөх журмыг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно.

Судалгааны арга:

Энэхүү судалгааг хийхдээ:

- Ажиглалтын арга,
- Бичиг баримт судлах арга,

- Бүлгийн ярилцлага
- Туршилтын арга
- Асуулгын арга,
- Ярилцлагын арга,
- Математик статистикийн аргуудыг хэрэглэсэн болно.

Судалгааны шинэлэг тал нь:

Сурагчдын дүрэмд заасан үүргийг биелүүлэх зорилгоор хүүхэд бүрт “Хариуцлагын карт”-ыг нээн хөтөлж, тэднийг хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлж байгаа явдал юм.

Судалгааны ач холбогдол нь сургуулийнхаа сурагчдын хүмүүжил, төлөвшлийг сайжруулах “Хариуцлагын карт”-ыг боловсруулан хэрэгжүүлснээрээ ололттой юм.

Энэхүү картын журмыг боловсруулан хэрэгжүүлснээр сурагчдын дундах харилцааны зөрчил арилж, үе тэнгийнхний дарамт багасан, сурагчдын дүрмийн хэрэгжилт сайжирна. Цаашид бусдад түгээх, нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулна.

Нэгдүгээр бүлэг:

Үүрэг, хариуцлагын талаарх онол практикийн зарим асуудал

1.1 Үүрэг гэж юу болох, түүний ангилал:

Мууг эсэргүүцэх, сайныг эрхэмлэх ёс суртахууны чин эрмэлзлэлээс үүдэн гарч байгаа бүхнийг зайлшгүй биелүүлэхийг үүрэг гэж ойлгоно. Үүрэг хүлээнэ гэдэг нь ёс журам сахих явдал юм. Үүрэг нь нийгэм, түүний гишүүдийн хоорондын харилцааг тогтмолжуулан зохицуулах арга юм. Энэ утгаараа үүрэг нь бусдын, нийгмийн, өөрийнхөө өмнө хүлээх хувь хүний хариуцлагын ухамсрын мөн чанарыг илэрхийлдэг ойлголт юм.

Толь бичигт: үүрэг гэдгийг “биедээ дааж авсан хариуцан гүйцэтгэх зүйл” гэж тодорхойлсон бол “үүргээ биелүүлэхдээ баяр хөөрийг амсч буй хүн л жинхэнэ эрх чөлөөтэй амьдарч байгаа хүн” гэж Цицерон хэлсэн байдаг. [1.1343]

Үүргийг 4 ангилах ангиллыг гүн ухаантан Г.Гегель хийсэн. Энэ нь:

- Өөрийн
- Гэр бүлийн
- Төр улсын
- Бусдын гэж ангилна. [15.3]

Үүрэг нь:

- Ёс суртахууны /ухамсарлагдсан/,
- Эрхийн /албадлагын/ гэсэн 2 янз байна.

МУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “Хүүхдийн журамт үүргийг 6 зүйлээр зааж өгсөн” байдаг.

Мөн ЕБС-ийн суралцагчдын дүрэм [4.2]-ийн заалтанд: “...Гудамж талбай, сургууль, олон нийтийн газарт бусадтай зөв боловсон харьцаж, нийгмийн хэв журмыг сахин биелүүлнэ”. “Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, тамхи татах, бүдүүлэг үг, хараал хэлэх, бусдыг заналхийлэх, залилах, хуурч мэхлэх зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийг жигшинэ” гэх мэтээр ёс зүйн үүргүүдийг зааж өгсөн байдаг.

1.2 Хариуцлага гэж юу вэ?

Хариуцлага гэдэг нэр томъёо латин хэлний /respondere-хариуцах/ гэдэг үгнээс гаралтай “хариуцлага”, “хариуцлагатай байдал” хэмээх ухагдахуун анх XV зууны хоёрдугаар хагаст эрх зүйн сургаалд хэрэглэгдэж, буруутай этгээд гэмт хэрэгтээ харицлага хүлээх учиртайг заадаг байжээ.

Хариуцлага гэдэг нь хүн өөртөө оногдсон үүрэг даалгаврыг биелүүлэх явцдаа хийж байгаа үйлдлээ бүрэн ухамсарлаж, үйл ажиллагаанаасаа гарах бурууг өөртөө хүлээх чадвар билээ.

“Монгол хэлний тайлбар толь”-д хариуцлага гэдгийг “Ажил үүргийг биедээ хүлээсэн”-ийг хэлнэ гэсэн бол ёс зүйн шинжлэх ухаанд хариуцлагыг “Бие хүний ёс суртахууны үйл ажиллагаа, түүний үүргийн зохицол нийцэл” гэж үздэг.

Хариуцлага нь нийгмийн үнэт зүйлс, хэм хэмжээ, дүрэм журмыг хүлээн авч даган мөрдөх хамтын үйл ажиллагааны явцад төлөвших бие хүний шинж юм.

Хүүхдэд хариуцлага суулгаж, хүмүүжүүлж эхлэх хамгийн тохиромжтой нас бол 3-3,5 насны үе. Харин 5-7 насанд хүүхдийн хариуцлага нэмэгдэж, буруу зөвийг ялгаж салган ухамсарлах чадвартай болдог.

Бид сурагчдад мэдлэг олгохоос гадна тэднийг ирээдүйн амьдралд бэлтгэх, төлөвшүүлэх үүргээ хэрэгжүүлж чадвал нийгмийн амьдралыг авч явах хойч үе маань хариуцлагаа ухамсарладаг болно гэсэн үг.

Хүслийн хязгаараа бусад хүмүүсийн сонирхолтой зохицуулж мэддэггүй хүн хэзээ ч сайн иргэн болж чадахгүй. Тэгшхэн ногоон талбай дээр бөмбөг тогломоор санагдавч цэвэр агаар сэлбэж байхын тулд тэнд тоглож болохгүй. Хүүхдийг багаас нь хүслээ

жолоодож сургахгүй бол энэ нь аажимдаа дур зоргоороо, хүссэн бүгдээ хийх гэсэн хүмүүжилгүй хүн болгоно.

Тэгэхээр “хариуцлага гэдгийг хэн нэгний өмнө, хэн нэгний төлөө үүрэг хүлээнэ” гэж ойлгож болно.

Бид тэгвэл хариуцлагыг юугаар хэмжих вэ? хэрхэн сайжруулах вэ? гэдэг асуулт гарна. Хориглох, хязгаарлах аястай дүрэм, журам, түүнд тохирсон шийтгэл ч байдаг. Өсвөр насанд шийтгэл хортой ч гэж ярьж, бичих нь элбэг. Тийм болохоор бид ямар аргыг хэрэглэх вэ?

Бид эрх зүйт төрд амьадрч байна, нийтээр дагаж мөрдөх эрх зүйд ч гэсэн хориглох, хязгаарлах заалтууд байдаг. Зөрчвөл ял шийтгэл оногдуулдаг. Ардын уламлалд ч “Цээрлэх ёсон” гэж бүтэн салбар бий. Бид хориглож, хязгаарласнаараа хүний эрхийг зөрчдөггүй. Харин ч хамгаалдаг.

“Шийтгэлийн зорилго нь хэрэг хийсний төлөө залхааж, дахин давтахаас айлгахын тулд биш, гагцхүү хүүхдэд бурууг ухамсарлуулахад оршино”.

В.А.Сухомлинский хэлэхдээ хүүхэд сайн зүлийг хийгээд ирэхээр ирэхээр хүүхэд аяндаа муу зүйлээс татгалзаж, зөв үйлдэл хийдэг болж улмаар тэр нь зуршил болдог.

“Зуршил суугаад ирэхээр үйл ажиллагаа автоматжиж, явал зохих ёстойг заншлын дагуу гүйцэтгэх болно” [2.4]

Оросын нэрт сурган хүмүүжүүлэгч К.Д.Ушинский сайхан дадал заншлыг “хүн өөрийн мэдрэлийн системд агуулсан ёс суртахууны капиталтай зүйрлэсэн” юм. Энэ капитал тасралтгүй өсөх ба хүн аьдралынхаа туршид түүний хүүг авч ашигладаг. Харин муу зуршил бол төлөөгүй хүүтэй адил бөгөөд тэр нь хүнийг бүрэн дамбууралд хүргэж болно. [2.4]

1.3 Үүрэг, хариуцлагын нэгдэл:

Үүрэг хариуцлага хоёрыг салгаж боломгүй. Үүргийг дагаж хариуцлага бий болдог. Аливаад хариуцлагатай хандах нь хүний сайн чанарын нэг илэрхийлэл юм. Хариуцлага нь үүргийн биелэлтийн хяналт. Үүрэг, хариуцлагатай салшгүй холбоотой зүйл нь эрх, эрх чөлөө юм.

Деонтологи /deontology/ буюу грекийн deon-үүрэг, хариуцлага, logos-сургаал, үг гэсэн үгнээс гаралтай. Үүрэг хариуцлагатай холбоотой асуудлыг авч үздэг ёс зүйн онолын үзэл баримтлал, хэсэг юм.

Энэхүү нэр томъёо, ойлголтыг анх Английн гүн ухаантан, хуульч И.Бентам /1748-1832/ боловсруулж, шинжлэх ухаанд оруулжээ. Тэрээр “хувь хүний ёс зүй ба хууль зүйн

урлаг ямагт хамт оршдог” гэж тэмдэглээд “деонтологийн гол зорилго нь нийгмийн зан байдалд хувь хүмүүсийн зан байдлын шинжийг хэвшүүлэхэд оршино” гэжээ.

Мөн нэрт судлаач, Я.Н.Засурский: “деонтологи бол юуны өмнө батлагдсан хуулийг хэрэгжүүлэх, ухамсарлан ойлгох явдалтай холбоотой сэтгүүлчийн хариуцлага үүрэг, эрх мөн” гэж тодорхойлжээ.

Деонтологи нь өөрийн гэсэн ойлголтын тодорхой аппараттай байдаг. Тэдний дотор үүрэг, хариуцлага, практик сонирхол, аз жаргалтай, сэтгэл ханамжтай, амь бие хайрлахгүй байх зэрэг ойлголт гол байр эзэлдэг.

Деонтологийн үзэл баримтлалын үндсэн зорилго нь хувь хүний соёлд бодитой оршиж буй албан үүрэг, хариуцлагын үзэгдэлтэй ямар нэг хэмжээгээр тохирсон үүргийн “хамгийн шилдэг хэв маяг”-ийг боловсруулахад оршино.

“Үүрэг хариуцлага гэдгийг хийхээр биедээ хүлээсэн ажил, амлалт, түүнийгээ сайтар хийж гүйцэтгэх ухамсар” гэж тодорхойлжээ.

Хоёрдугаар бүлэг:

“Хариуцлагын карт”-ыг туршин хэрэгжүүлсэн байдал:

2.1 “Хариуцлагын карт” хэрэглэх болсон шалтгаан:

Судалгааны аргачлал:

1.Зорилго: Энэхүү журмыг хэрэгжүүлэхийн өмнө тэдний үүргийг ухамсарлуулах оновчтой аргыг эрэлхийлэн сурагчидтай ярилцаж, тэднээс түүврийн аргаар “сурагчдын хариуцлагыг сайжруулах”-ын тулд хийж болох ажлын талаар судалсан. Хариуцлага алдсаны дараа шийтгэх бус алдахаас нь өмнө сэрэмжлүүлэх зорилгоор дорвитой ажил хийх хэрэгтэй гэдгийг олж харсан юм. Тэгээд ч хүний аливаа үйлдэл бүхний өмнө ил байдаг учраас энэ нь шударга хэрэг байлаа.

2.Судалгааны асуулга:

1. Чи сурагч хүний үүргийн талаар ямар мэдлэгтэй вэ?
2. Сурагчид үүргээ яаж биелүүлдэг вэ?
3. Хамгийн их зөрчигддөг заалт аль нь вэ?
4. Үе тэнгийнхний дарамт шахалт байдаг уу?
5. Сурагчдыг үүргээ биелүүлж ухамсарладаг болгохын тулд юу хийвэл зүгээр вэ?

3.Судалгааны үйл явц: Энэхүү судалгааг 2015 оны 2-р улиралд явуулсан.

4.Судалгааны хамрах хүрээ: 1-5-р ангийн 119 сурагчдаас авч, үр дүнг боловсруулсан.

5. Үр дүнг нэгтгэсэн арга:

1. Чи сурагч хүний үүргийн талаар ямар мэдлэгтэй вэ?

А.Маш сайн-7% Б.Сайн- 18% В. Дунд зэрэг-81% Г.Мэдэхгүй-43%

2. Сургууль дээр сурагчид үүргээ яаж биелүүлдэг вэ?

А. Сайн-26% Б.муу-73% В.Огт биелүүлдэггүй-55%

3. Хамгийн их зөрчигддөг заалт аль нь вэ?

А. Хичээл хоцролт-48% В.Дүрэмт хувцас-35%

Г.Нэр хоч өгөх-39% Д.Мөнгө нэхэх- 16%

4. Үе тэнгийнхний дарамт шахалт байдаг уу? Байдаг бол нэрлэж бичнэ үү?

Байдаг – 15% хааяа байдаг-14% хэл амаар доромжилдог-15%

Мөрөлдөг-12% мөнгө нэхдэг- 9% тамхи тат гэж шахдаг- 4%

Зоддог- 10% Дарамт үзүүлдэг- 6%

Дарамт үзүүлдэг хүүхдийн нэрийг нь бичсэн-15%

5. Сурагчдыг үүргээ биелүүлж ухамсарладаг болгохын тулд юу хийвэл зүгээр вэ?

А. Хариуцлага тооцдог-33% Б. Үүргийг нь биелүүлдэг болгох-25%

В. Үнэлгээ тавьдаг болох- 28% Г. Өдөр бүр хяналт тавьдаг болох- 14%

2.2 “Хариуцлагын карт” хэрэглэх журмаас:

Хариуцлагын карт, түүнийг хөтлөх:“Хариуцлагын карт”-тай байна. Картын загвар нь:

1	1	1	2	2	2	3	3	3	4	
 СУРАГЧИЙН ХАРИУЦЛАГЫН КАРТ АНГИ: ОВОГ: НЭР: ХАРИУЦЛАГА ХАМГИЙН САЙН ТӨЛӨВШИЛ										
										4
										4
										5
										5
										5
										6
										6
										6
										6
10	10	10	9	9	9	8	8	8	7	



Картын нүүр хэсэг

“Хариуцлагын карт” нь анги удирдсан багш, ангийн даргад хадгалагдаж, тухайн сурагч зөрчил гаргасан тохиолдол бүрт тусгайлан тэмдэглэгээ хийгдэнэ. Сурагч бүр хүссэн үедээ хариуцлагын карттайгаа танилцах эрхтэй.

“Хариуцлагын карт”-аар дор дурдсан зөрчлүүдийг тооцно. Үүнд:

1. Сургууль, нийтийн болон хувийн өмч, эд хогшлыг гэмтээсэн /бусдын өмчид халдсан, /хулгайлсан/, зөвшөөрөлгүй авсан, ашигласан, санаатай ба санамсаргүй гэмтээсэн/
2. Бусдыг гомдоосон, хэл амаар доромжилсон, харилцааны зөрчил гаргасан /багш сурган хүмүүжүүлэгчид болон ахмад настан, найз нөхөд болон бусад хүмүүс/
3. Хог цаас хаясан, орчныг бохирдуулсан /ус асгах, 00-ын өрөөгөөр боловсон бус үйлчлүүлэх/, иртэй үзүүртэй зүйл авч явах, хана, шал, хаалга, цонх зэргийг гэмтээх,
4. Чанга дуу чимээ гаргаж олныг цочроох /хөгжим, дуу авианы хэрэгсэл болон хашгирах, зандрах г м/, сургалтын үеэр гар утас болон бусад мэдээлэлийн хэрэгсэл ашиглах, хичээлийн цагаар дэмий сэлгүүцэх, сургалтаас өөр зүйл хийх /тоглох, коридороор явах, цайны газраар үйлчлүүлэх, сургуулиас гарч явах г м/
5. Дэг журмын зөрчил /хөдөлгөөний урсгал сөрөх, сургууль дотор завсарлагааны дэг журам зөрчих, зодолдох, ноцолдож хар зураас гаргах г м/
6. Бусдын биед гэмтэл учруулсан /эрүүл мэндэд халдсан, их бага хэмжээний хохирол учруулсан/
7. Дүрэмт хувцасны зөрчил гаргасан /цагаан цамц, дүрэмт хувцсыг бүрэн өмсөөгүй, батлагдсан загвараас өөр хувцас өмсөх, сургууль дотор хувцсаа сольж өмсөх/.
8. 7 хоногт 2 ба түүнээс дээш удаа, сард 3 ба түүнээс дээш удаа, улиралд 7-оос дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээлээс хоцорсон.
9. 7 хоногт 3 ба түүнээс дээш цаг, сард 10 ба түүнээс дээш цаг, улиралд 20 ба түүнээс дээш цагийн хичээл тасалсан.
10. Гэрийн даалгавар /7 хоногт ба түүнээс дээш удаа даалгавар хийхгүй ирэх/

“Хариуцлагын карт”-аар сурагчдад хариуцлага тооцох:

1. Жижүүр, ангийн багш, нийгмийн ажилтан, ангийн идвэхтэн сурагчид нь хичээлээс хоцорсон сурагчдын овог, нэрийг тухай бүрт нь тэмдэглэнэ.
2. 7 хоног бүрийн Баасан гарагт “Хариуцлагын карт”-ыг **цоолох** аргаар тэмдэглэл хийж, энэ талаарх мэдээллийг даваа гараг бүр нийтэд уншиж, танилцуулна.
3. 7 хоногт давтан зөрчил гаргасан бол энэ тухай тэмдэглэлээ хариуцлагатай жижүүрийн дэвтэрт бүртгүүлэн ангийн дарга картанд тэмдэглэл хийнэ.

4. 1-10 дахь заалтуудыг удаа дараа зөрчиж, картанд 3 ба түүнээс дээш удаа тэмдэглэл хийлгэсэн сурагчдад “Сануулах хуудас” өгөх, ангийн хурлаар хэлэлцэн, нийгмийн ажилтанд танилцуулан зөрчил дахин давтагдвал сургуулиас хасах хүртэл арга хэмжээ авна.

Анхааруулах зүйл:

1. “Хариуцлагын карт”-ыг хаяж гээх, бусдад дамжуулахыг хориглоно.
2. “Хариуцлагын карт”-нд тэмдэглэл хийлгэсэн сурагчид тухай бүрт нь карттайгаа танилцаж, гарын үсгээ зурна

2.3 “Хариуцлагын карт”-ыг хөтөлж ирсэн туршлага, үр дүн:

Картанд тэмдэглэл хийлгэсэн сурагчдын бүртгэл /2015-2016 оны хичээлийн жилийн сүүлийн эхний 2 улирлын байдлаар/

дд	нэрс	1 тэмдэглүүлсэн		2 тэмдэглүүлсэн		3 тэмдэглүүлсэн		нийт
		III ул	IV ул	III ул	IV ул	III ул	IV ул	
1	Амуударь	0	0	0	0	0	0	0
2	Баярбаясгалан	2	12	7	3	2	1	27
3	Буянзаяа	0	2	0	0	0	0	2
4	Нандинцэцэг .Г	0	0	0	0	0	0	0
5	Галиндэв	0	0	0	0	0	0	0
6	Тэргэл	0	0	1	1	0	0	2
7	Золбоо	0	0	0	0	0	1	1
8	Гантулга	1	1	0	2	2	0	6
9	Ариунбаяр	0	1	0	0	0	0	1
нийт		3	16	8	6	4	2	39

Дээрх бүртгэлээс харахад:

1. Сурагчид анги ахих тусам “хариуцлагын карт”-нд тэмдэглэл хийлгэсэн байдал өсч байгаа нь харагдаж байна. Энэ нь хүүхэд томрох тусам үүргээ мэддэг боловч сахин биелүүлэх, хариуцлагаа ухамсарлах тал дээр дутагдал ихээр гардаг нь ажиглагдаж байна.

Үүнд дүгнэлт хийж, судалж үзэхэд:

- Том хүүхэд болсон мэтээр сэтгэж, биеэ даах гэсэн хандлага ихэссэн,

- Эцэг эхийн үлгэр дууриал дутмаг,
- Хичээлээс хоцрох байдал их байна гэж үзвэл, хүргүүлдэг байснаа больж өөрсдөө нийтийн тээврээр зорчих болсноос,
- Өөрөөсөө дүү насны хүүхдийг дээрэлхэх, шоглох байдал ихэсдэг зэрэг бодит шалтгааныг тоочсон байна.

Иймээс бид сурагчдад журмыг сайтар танилцуулах, ажиглалтаа гүнзгийрүүлж, журмын биелэлтийг сайжруулах тал дээр голлон ажиллаж байна.

2.Сурагчдын ихээр гаргаж, картанд тэмдэглүүлсэн зөрчлүүдийг жагсаавал:

- Хичээлээс шалтгаангүй хоцрох – 36%
- Сурагчийн дүрмийн зөрчил гаргах – 22%
- Дүрэмт хувцасны зөрчил гаргах – 14%
- Бусдыг хэл амаар доромжлох, гомдоох - 12%
- Хичээл таслах – 5%
- Бусдын биед гэмтэл учруулах – 4%
- Сургууль, нийтийн, хувийн өмчид халдах – 3%
- Хог цаас хаях-3%
- Бусад-1%

Бидний цаашид хэрэгжүүлэх ажиллагаа маань хичээлийн цаг ашиглалтыг сайжруулах, тэдний хувийн зохион байгуулалтыг өндөржүүлэх, дүрэмт хувцсыг журмын дагуу зөв өмсөх, сурагчдын хоорондын зөрчлийг багасгах зэрэгт зориулагдах юм.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Даяаршлагдаж буй хүн төрөлхтний хөгжлийн түүх хурдсаж энэ их үсрэнгүй хөгжилтэй хөл нийлүүлэн алхах нь аль ч улс орны ард иргэдийн хувьд нэн тэргүүний шаардлага болж байна. Энэ их мэдээ мэдээлэл, харилцаа холбоон дунд хүмүүс бид хоцрохгүй эн зэрэгцэн амьдрах нь зүй ёсны хэрэг бөгөөд ингэхийн тулд нэн түрүүн бид хүүхэд нэг бүрийг хөгжүүлж ирээдүйн чадварлаг иргэн болгон **төлөвшүүлэх** нь хамгийн зөв арга билээ. Монголын боловсролын тогтолцоо сүүлийн хэдэн жил эрчимтэй өөрчлөгдөж “Зөв монгол хүүхэд хөтөлбөр”, “Авьяас хөтөлбөр” зэрэг хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бодлого төлөвлөлтүүдийг хэрэгжүүлж байна. Иймээс “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” гэдэг учир багш нар бидний нэгэн гол зорилго нь завхөн хүүхдэд мэдлэг

олгохоос гадна зөв иргэн болгон төлөвшүүлж, үүргээ ухамсарладаг иргэнийг бий болгох явдал юм.

Энэ зорилгын хүрээнд би “**Хүүхэд бүрийн хөгжил, төлөвшилд үүрэг хариуцлагын нэгдэл чухал болох нь**” сэдвээр судалгаа хийж **хариуцлагын картыг** санаачлан туршин хэрэгжүүллээ.

Үүний үр дүнд:

1. Сурагч бүрт “Хариуцлагын карт”-ыг хөтөлснөөр тэд үүргээ сайн биелүүлдэг болж төлөвшиж байна.
2. Энэхүү картыг сурагчдыг төлөвшүүлэх бусад үйл ажиллагаатай хослуулан хэрэглэснээр үр дүнд хүрч байна.

Иймээс багш нар бидэнд хариуцлагын карт ажиллуулах замаар хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, хандлага, төлөвшлийг нь сайжруулах нөөц боломж бүрэн байгаа бөгөөд гагцхүү багш сурган хүмүүжүүлэгч бид нарын хичээл зүтгэлээс л шалтгаалах юм. Ер нь хүүхэд бүрийн онцлогт нь тохируулан хариуцлагын картыг ашиглаж чадвал багшийн ажлын үр дүн сайжирч, бичиг цаасны ажил багасч, хүүхдэд зориулагдсан цаг гарах боломжтой, хүүхэд ч жинхэнэ утгаараа бие даан сурч, төлөвшил, хандлага нь сайжрах боломжтой болох нь туршилтын явцаас харагдаж байна. Хүүхдийг төлөвшүүлэх үр дүнтэй арга хэрэгслийн эрэл хайгуул сурган хүмүүжүүлэх ухааны түүхийн туршид үргэлжилсээр байгаа бөгөөд энэхүү танилцуулж байгаа “Хариуцлагын карт”-ыг анги, хамт олон, цаашлаад сургуулийн хэмжээнд хэрэглэх боломжтой шилдэг аргуудын нэг болгон улам сайжруулах нь миний цаашдын зорилго байх болно.

" Нэг, хоёр жилийн цаадахыг хардаг улс хүнсээ бэлддэг

Арав, хорин жилийн алсыг хардаг улс мод тарьдаг

Зуун жилийн алсыг хардаг улс хүнээ зөв төлөвшүүлэх
бодлого гаргадаг"

НОМ ЗҮЙ

А.Ном зохиолууд:

1. Баярсайхан Б. Монгол хэлний тайлбар толь. УБ., 2011
2. Бушелева Б.В. Боловсон зан байдлын тухай. Москва., 1988
3. Ган-Өлзий Ч. Хүмүүнлэгийн 3 ертөнцийн гоц чанарыг судлахуйн чандмань эрдэнэ. УБ., 2011
4. ЕБС-ийн суралцагчдын үлгэрчилсэн дүрэм. УБ., 2003
5. ЕБС-ийн үлгэрчилсэн дүрэм. УБ., 2011

6. МУ-ын Боловсролын тухай хууль. УБ.,2002
7. Нийслэлийн 1-р дунд сургуулийн сурагчдын дагаж мөрдөх журам. УБ., 2009
8. Цэрэнхүү Ц нар. Сурагчийн үнэлгээ. УБ., 2013
9. Столетов В.Н. Хүмүүжлийн тухай харилцан яриа. Москва., 1988
10. Сухомлинский В.А. Шилмэл зохиолууд. УБ.,1988
11. Хариуцлагын картын журам, УБ., 2010
12. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль. УБ., 1996

Б.Сайтууд:

13. www.orosshkolton.mn /Орч. Ё.Одончимэг. Хүүхдээ хариуцлагатай хүн болгож хөгжүүлье гэвэл/
14. [mn.wikipedia.org/wiki /Деонтологи/](http://mn.wikipedia.org/wiki/Деонтологи/)
15. [www. olloo.mn](http://www.olloo.mn) /Док Б.Оюунчимэг. Үүрэг хариуцлагаа биелүүлж байж эрхээ эдэлж, эрх чөлөөтэй байна/